

***Аялгууг сонсоод 1-4 дүгээр даалгаврыг гүйцэтгээрэй.**

1. *Сонссон бүтээлийн эхний хэсэгт тохирох хурдыг сонгоорой.

A. Дунд зэрэг B. Хурдан C. Хурдавтар D. Удаан

2. *Сонссон аялгуу хэдэн хэсгээс бүтсэн байна вэ? Тохирохыг сонгоорой.

A.   B.    

C.    D.   

3. *Сонссон бүтээлийн 2 дугаар хэсгийн хурдыг тодорхойлоорой.

A. Дунд зэрэг B. Хурдан C. Маш хурдан D. Удаан

4. *Сонссон бүтээлийн утга санааг илэрхийлэхэд тохирох зургийг сонгоорой.

A.  B.  C.  D. 

5. *Сонссон бүтээлийн гол аялгууг ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдөж байна вэ?

A.  B.  C.  D. 

6. Монгол ардын уртын дууг дуулах аялгаар нь зөв ангилсан хувилбарыг сонгоно уу.

A. Боржигон, Бэсрэг, Төв халх, Суман
 B. Бэсрэг, Айзам, Суман, Боржигон
 C. Бэсрэг, Айзам, Боржигон, Төв халх
 D. Төв халх, Баян бараат, Боржигон, Зүүн аймгийн

7. Монгол ардын уртын дууг бүтэцээр нь гурав ангилдаг бол хамаарахыг сонгоно уу.

A. Төв халх дуу B. Боржигон дуу C. Гүр дуу D. Суман дуу

8. Хоосон нүдэнд тохирохыг сонгоорой.

Хөгжмийн зэмсэг	Хөгжимдөх арга барил	Хөгжмийн зэмсгийн төрөл зүйл	Эгшиглэгээний онцлог	Хөгжмийн зэмсгийн хөг багтаамж
Ятга	Хуруугаар чимхэх буюу этэн товшино	?	Уянгалаг зөөлөн	Бага октавын ре – III октавын ре

A. Чавхдаст нумт

B. Чавхдаст цохивор

C. Чавхдаст товшвор

D. Үлээвэр хөгжим

9. Хөгжимт аман зохиолын төрлүүд аль нь вэ? Зөв хувилбарыг сонгоно уу.

A. Хөөмий, исгэрээ, цуур

B. Монгол ардын богино дуу, уртын дуу

C. Ерөөл, магтаал, тууль

D. Бий биелгээ

10. Ардын дуу хөгжмийн аялгуу, дуурьслыг боловсруулан баяжуулж, рок хэв маягаар найруулах үндсэн дээр бий болсон рок хөгжмийн чиглэл аль нь вэ?

A. Этник

B. Фолк рок

C. Этно рок

D. Этно джаз

11. бийгийн намба төрх нь товшуурын савардан татах хэмнэлд гоц тохирсон байдаг. Үүгээрээ ихэлийн татлагаар биелдэг бийгээс өөр дэгтэй.

A. Захчин

B. Хотон

C. Урианхай

D. Торгууд

12. Аль нь туульс магтаал вэ?


A. Уйлган шар магтаал

B. Авралтай баян хан хөхий магтаал

C. Хөгнө ханы магтаал

D. Алтайн магтаал

13. Монгол ардын дуу “Дөрвөн уул” дууны “B” хэсэгт хөөмийн ямар төрлийг ашигласан байдаг вэ?



A. Хархираа

B. Шахаа

C. Исгэрээ, шахаа

D. Хархираа, шахаа

14. Монголчууд эрт дээр цагаас зан үйлтэй холбогдох аялга үг, уриа дуудлага хэлж өвөрмөц ёс заншил гүйцэтгэсээр иржээ. Мал ээнэгшүүлэх аязууд тойг, гүүргий, уухай, гийнгоо, цуйглах, хөөс, тариа хураах үтрэмийн дуу зэрэг нь ямар дууны төрөлд хамаарах вэ?

A. Домогт дуу

B. Ёс заншлын дуу

C. Хөдөлмөрийн дуу

D. Гүр дуу

15. Монгол ардын уртын дуу “Тосонгийн орой” дууны ноот бичлэг дэх тодруулсан хэсэг ямар үүрэгтэй вэ?



- A. Эгшиг хоорондын зайг тодорхойлно.
- B. Эгшгийг тодорхойгүй хугацаанд удаан барина.
- C. Эгшгүүдийг огцом тасалдангуй дуулна.
- D. Эгшгүүдийг тасралтгүй үргэлжлүүлэн дуулна.

Эрт цагт нэгэн хүү эхийн хамт амьдардаг байжээ. Тэр хүү өөрийн хамгаас хайртай морьтой юмсанж. Гэтэл хятад худалдаачны өр нэхэгдэж хайртай морио уйлан, хайлан байж алс холын нутагт өгч явуулжээ. Хэдэн жилийн дараа гэрийн гадаа морь янцгаах чимээгээр гараад хартал, хайртай морь нь уян дээрээ өрөөлтэй гүйж ирсэн байв. Хүүгийн сэтгэл нь уярч баярлан, холын Бээжингээс эх нутгаа, эзнээ зорин хүнд бэрхийг туулан гүйж ирсэн мориндоо зориулан бий зохиосон домогтой.

16. Дээрх домог ямар бийгийн домог вэ? Сонгоорой.
- A. “Жороо морь” бий
 - B. “Өрөөлт халтар” бий
 - C. “Эрээн хавирга” бий
 - D. “Баяд” бий
17. Буриад ардын “Баавай чингис” дууг ашиглан монгол хөгжмийн уламжлалт төрлүүдийг орчин үеийн хөгжмийн хэл найруулга, арга барилтай хослуулсан уран бүтээлийг сонгоно уу.
- A. Хөсөгтөн хамтлаг “Самгалдай”
 - B. Алтан ураг хамтлаг “Давалгаа”
 - C. Бөртэ хамтлаг “Говь”
 - D. Жонон хамтлаг “МонголZ”
18. “Дөрвөн настай халиун” дуу нь дуулах хэв маяг, аялгууны цараа багтаамжийн хувьд ямар дууны төрөлд хамаарах вэ? Сонгоно уу.
- A. Монгол уртын дуу
 - B. Монгол ардын богино дуу
 - C. Бэсрэг уртын дуу
 - D. Гүр дуу